Өвөрхангай. Бүсийн  сургалт.
“Хичээлийн судалгааны аргазүй” сургалт
2011.09.16-17

# Багшлах аргазүйн хөгжил - хичээлийн судалгаа

М.Ганбат  МУИС. ФЭС. ФБТ

# Илтгэлийн агуулга

- Цогц чадамж эзэмших сургалт
- Суралцахуй ба багшлахуйн  сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал ба мэргэжлийн дидактикийн үндэс
- Хичээлийн судалгааны аргазүй
- Хичээлийн судалгаа ба багшлах аргазүйн хөгжил

# Өмнөтгөл

- БСШУ-ны сайдын тушаал, ЕБС-д ажиллагсадын ажлын байрны тодорхойлолт:
- Багш “**Цогц чадамжид суурилсан стандарт**”-ыг хэрэгжүүлнэ.

Ярилцлага:

- Цогц чадамжид суурилсан стандарт –ын дор юуг ойлгож байна ?
- Хэрэгжүүлж чадаж байна уу?
- Мэргэжил дээшлүүлэх сургалтаас юуг хүсэн хүлээж байна?

# Цогц чадамжид суурилсан боловсролын стандарт (2005)

Цогц чадамжийн загвар ( 3 элементтэй ) хэрэглэсэн.

- Цогц чадамжийн мужуудад ЮНЕСКО-ын “ суралцахуйн” тулгуур 4 баганыг сонгосон:
  - Learning to know (мэдэхийг сурах)
  - Learning to do(бүтээхийг сурах)
  - Learning to be(оршин байхыг сурах)
  - Learning to socially live together(хамтдаа нийгэмшин амьдрахыг сурах)
- Агуулгыг сонгохдоо шинжлэх ухааны агуулгад биш харин дээрх цогц чадамжууд, түүнд харгалзах чадваруудыг эзэмшүүлэх агуулгыг сонгож “ай” (domain) ухагдахуунаар илэрхийлсэн
- Цогц чадамжийн хөгжлийн түвшинг суралцагчийн танин мэдэхүйн түвшинд баримжаалсан

# Цогц чадамж (competence)-ухагдахуун

- Сургалтын “гаралт “-д баримжаалсан боловсролын стандартууд
- Сургалтын чанарын олон улсын хөтөлбөрүүд, PISA
- **Нийгмийн хөгжлийн онцлог:** мэдээлэл харилцаа, мэдлэг мэдээллийн хурдац, насан туршдаа сурах
- **Сургалт**: нөөц мэдээллийг дамжуулах бус сурах, мэдэх, чадах аргад сургах
- Сэтгэл судлал, дидактик, сху, .......
  - Сургалтын шинэ онол, аргууд
  - Төрөл бүрийн салбар дахь өндөр мэргэжилтнүүдийн талаарх судалгаа
- Боловсролын(суралцахуйн сэтгэл судлал, мэргэжлийн дидактик,...)  судалгаа

# "Цогц чадамж"- ухагдахууны хэрэглээ: боловсролын зорилгыг нарийвчлахад

Ерөнхий боловсролын зорилго:

- Хийсвэр түвшинд томьёологдсон
- Үнэлгээ хийхэд бэрхшээлтэй

↕

Цогц чадамж (competence)

↕

Хичээлийн зорилго:

- Суралцагчдад мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд хувь нэмэр оруулах
- Үр дүнг жишиг даалгавраар үнэлэх боломжтой

# “Цогц чадамж”-ухагдахууны тодорхойлолтоос

Цогц чадамж:

- Тодорхой асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай оюуны (когнитив) чадвар, дадал
- Энэхүү чадвараа тодорхой нөхцөл байдалд асуудлыг  амжилттай, хариуцлагатай шийдвэрлэхэд  ашиглаж чадах нийгмийн (социал) чадвар
- **Цогц чадамж: мэдлэг, чадвар, дадал, хандлага, төлөвшил, ёс зүй**
  - Оюуны чадвар: Боловсрол
  - Социал чадвар: Хүмүүжил
- Хичээл бүр суралцагчдын боловсрол, хүмүүжилд хувь нэмэр оруулж чадна.

# Цогц чадамжид суурилсан стандарт ба сургалтын хөтөлбөр

| | **Өмнөх ()** | **Шинэ стандарт ()** |
|---|---|---|
| Зорилго | Суралцагчдад ШУ-д баримжаалсан мэдлэг эзэмшүүлэх | Суралцагчид цогц чадамжууд эзэмших |
| Агуулга | Судлахуунд баримжаалсан бүлгүүд | Цогц чадамж эзэмшүүлэх агуулга |
| Арга зүй | Багш төвтэй заах арга<br>Гадны удирдлагатай суралцахуй | Сурагч төвтэй суралцахуй<br>Өөрийн удирдлагатай, хариуцлагатай суралцахуй |
| Үнэлгээ | Цээжилсэн, салангид мэдлэг | Цогц чадамж, чадварууд мэдлэг,чадварын өсөлт хөгжилт |

# Боловсролын шинэ стандартаар хөтлөгдөж буй арга зүйн шинэчлэл

- БДБС :Арга зүйн хөгжлийн үндэс: 6 зарчим
  - **Боломжийг тэнцүү олгох**
  - **Агуулгыг сонгох зарчим**
  - **Суралцахуйн**
  - **Багшлахуйн**
  - Технологийн
  - Үнэлгээний
- Сургалтыг боловсролын орчин цагийн онол, үзэл баримтлалд тулгуурлан явуулах шаардлага

# БДБС- Сургалтын 12 жилийн хөтөлбөр



# Цогц чадамж эзэмших сургалтын онцлог

- Суралцахуй ба багшлахуйг орчин цагийн онолын хүрээнд авч үздэг
- Сурах үйл ажиллагаа
  - Суралцагч өөрийн бүтээлч, идэвхитэй үйл ажиллагаагаар мэдлэг, чадвартай болох.
  - Суралцагч сургалтын үйл ажиллагаанд үүрэг хүлээж оролцоно
- Багшлах үйл ажиллагаа
  - Суралцагчийн сурах орчинг бүрдүүлж, дэмжинэ.
  - Сургалтын бүтээлч аргуудыг санал болгох
- Сурагч багшийн бүтээлч хамтын ажиллагаа

# Суралцахуй ба багшлахуй

Суралцагчийн төрх байдал

- Багш хичээл, сургалтын ажлаараа энэхүү төрх байдлыг өөрчлөхийг оролддог
- Багшлахуй
- Багшлахуй нь суралцахуйгаас тусдаа хэрэгжих боломжгүй

Боловсрол, хүмүүжилтэй болох нь **сурч буй хүнээс** хамаарна

- Сургууль, багш зөвхөн дэмжлэг үзүүлж чадна
- Багшлахуй нь суралцахуйгаас тусдаа хэрэгжих боломжгүй

# Хичээлийн судалгааны цар хүрээ

- Хичээл гэж юу вэ?
  - Нарийн нийлмэл систем
  - Рационал ба нээлттэй систем
- Судалгаа гэж юу вэ?
  - Судлан шинжлэх үйл ажиллагаа
- Хичээлийн судалгаа
  - Сурган хүмүүжүүлэх ухаан, дидактикийн судалгааны нэг чиглэл
  - Багш бэлтгэх их сургуулиудын сургалтын хөтөлбөрт тусгагддаг хичээл
- ЕБС-ийн хичээлийн чанар, сурах ба багшлах үйл ажиллагаанд тооцох чухал асуудал
- Хичээлийг судлахтай холбоотой  бидний ойлголт, одоогоор бид “хичээлийн судалгаа” гэж орчуулаад байгаа “Lesson Study” ухагдахууны утга санаа яг ижил зүйл мөн үү?

# Хичээлийн судалгаа:

**Япон**:

- Хичээлийн судалгаа бол Японы боловсролын нэг онцлог, бренд
- Ìåéæèãèéí үеэс 1897 îí эхэлсэн
- Дайны өмнөх -дайны дараах -одоо гэж хуваах болно.
- Дайны дараа 1950-1960 оноос хүчтэй хөгжсөн

# АНУ:

Makoto Yoshida (New Jersey) :
*Jugyokenkyu -Lesson Study*
диссертаци

АНУ-ын судлаачид: “Lesson Study”-ын судалгаа 1998 анхны э/ш өгүүлэл
Catherine Lewis: *'research lesson*‘
1996- 2000

Одоо АНУ -ын 32 гаруй штат 335 сургуулийн 2300 гаруй багшийн хичээл

*Lesson Study:*
Япон → АНУ → Япон

# *Хичээлийн судалгааны хөгжил*

- Анх АНУ-д нэвтрүүлсэн.

Дэлхий дахинд түгэж байгаа

- Хятад
- Малайз
- Àâñòðàëè,
- Èðàí,
- Øâåä,
- Àíãëè çýðýã äýëõèéí îëîí îðîíä õè÷ýýëèéí ñóäàëãàà хийгдэж байна.

# *Хичээлийн судалгааны хөгжил*

- 1964 онд Японы “Боловсролын Аргазүйн Холбоо” байгуулагдсан.
- 2006 îíä

**Äýëõèéí Õè÷ýýëèéí Ñóäàëãààíû Õîëáîî -**

**The World Association of Lesson Studies, WALS байгуулагдсан.**

- APEC (Asian Pacific Economic Cooperation) Lesson Study **Project**

# Хичээлийн бүтэц (Япон)

- Stigler.J.W (1999)  TIMSS

Японы хичээл: “За эхлэцгээе”-ээс эхлэж, “Дууслаа” хүртэл эхлэл-өрнөл (дунд)-төгсгөл гэсэн үгээр төлөвлөгддөг. Сурагчдаар сайн бодуулж, гүнзгий ойлгуулахыг зорьдог.

- Асуулт бол санаа бодлыг өдөөх арга хэрэгсэл юм.
- Бодит зүйл хэрэглэгддэг.
- Сурагчдын алдаа нь сурах хэрэгцээ байгаа хэмээн бодож нэг хүүхдийн алдааг бүгдээрээ нягталдаг.
- Бодлогын талаар хамтран ярилцаж, сурагчдын бодсон (шийдэх) аргыг оролцуулан математикийн ухагдахууныг тодорхой ойлгохыг зорьж хамтран боддог. Сурагчид өөрсдийнхөө асуудал шийдвэрлэх аргыг бодож, ойлголтоо гүнзгийрүүлэхийн төлөө ажиллах явцдаа юмыг хэрхэн ойлгох аргад суралцдаг.

Америк, Германы хичээл:

- Багш эхлүүлж, цааш нь өөрөө үргэлжлүүлдэг. Багш жишээ гарган, сурагчид түүнийг дагадаг. Багш дүгнэдэг.

# “ jugyo kenkyu”- г утгачилан ойлгох асуудалд

- “Lesson Study”-ын талаар их хэмжээний судалгааны материал, ном, төсөл,интернет,.....
- Англи хэлээр бичигдсэн судалгааны материалуудад хэрэглэгдэж буй ухагдахуунууд
  - “Lesson Study”, “ jugyo kenkyu”, “kyozai kenkyu”, …
- Эдгээр ухагдахууныг  тайлбарлаж буй байдал:
  - Японы багш нарын үйл ажиллагаатай холбодог
  - Японы багш нараас та нарын хичээл яагаад ийм чанартай байдаг вэ? гэж асуухад бид “jugyo kenkyu” “kyozai kenkyu” хийдэг гэж хариулдаг.

## “What is Lesson Study?”:

- “Lesson Study” - Японы багш нар хичээлийнхээ  үр өгөөжийг илүү  дээшлүүлэх зорилготойгоор  өөрийнхөө практик үйл ажиллагааг системтэй судлан үздэг багш мэргэжилтний хөгжлийн процесс

**Анхаарах асуудал:**

Сургалт удирддаг, мэдээлэл боловсруулдаг хүмүүс (бодлого, шийдвэр гаргагчид,багш бэлтгэдэг их сургуулийн багш нар, боловсролын хүрээлэн, боловсролын газрын арга зүйчид)

| Jugyo kenkyu | Kenkyu jugyo |
|---|---|
| Lesson Study | Research lesson |
| Хичээлийн судалгаа | Судалгаанд суурилсан хичээл, судалгаатай хичээл |

# Хичээлийн судалгааны түвшин

- Шинэ арга зүйг олж судлахад зориулсан
- Сургалтын зорилготой (мэргэжил дээшлүүлэх сургалт гэх мэт)
- Туршлагатай багш нар залуу багш нартаа сургах (туршлага хуваалцах)
- Залуу багш нар туршлагатай багш нараасаа санал зөвлөмж авах (туршлага судлах)
- Ижил түвшний багш нар бие, биеэсээ суралцах




(1) Problem identification,(2) Class planning, (3)Class implementation,(4) Class evaluation and review of results, (5) Reconsideration of class,
(6) Implementation of class based on reconsiderations, (7) Evaluation and review,
(8) Sharing of results

Figure 1: Flowchart of Pedagogical Training (Stigler&Hiebert,1999)



Photo 1: A study lesson class with observers




Figure 3: National Training Conference for Teachers at the Elementary School Attached to the University of Tsukuba, held since the Meiji period.

Хичээлийн судалгааны үйл ажиллагаа нь багш нар хамтран хичээлийн төлөвлөлтөө хийхээс эхлэнэ. Багш нар тэдний ажлын туршлага, сурагчдаа ажигласан төлөв байдал, багшийн ном болон сурах бичиг дэх сайн туршлага, санаа зэрэгт тулгуурлан хичээлээ хэрхэн хамгийн сайн хичээл болгож болох талаар санаа бодлоо солилцоно. Энэхүү  алхмын эцэст хичээл заах детальчилсан төлөвлөгөө бий болно.

Дахин заах, сайжруулах

Хичээ
суда
тасра
үйл ажи

Энэ алхамд нэг багш нь төлөвлөсөн хөтөлбөрийн дагуу хичээлээ зааж, бусад багш нар нь ажиглалт хийнэ.  Ажиглалт хийх багш нар хичээлийн хөтөлбөртэй танилцсан байна.

Ажигласан багш нараас нэг багш тухайн хичээлийг өөр ангид дахин зааж, бусад нь ажиглалт хийнэ. Үүний үр дүнд хичээлийн арга зүй, төлөвлөлт улам илүү сайжирна.

Хэлэлц
явуу

Ажиглалт хийсэн бүх хүмүүс оролцох ба хамтран боловсруулсан хичээлийн төлөвлөлт арга зүйн талаар, түүнийг хэрхэн сайжруулах талаар санаа бодлоо хэлэлцэж дүгнэнэ.

# Хичээлийн судалгаа нь хичээлийн дүн шинжилгээ биш

- Хичээлийг ерөнхий талаас нь ажиглаж, түүний бүтцэд дүн шинжилгээ хийх нь хичээлийн судалгаа биш юм.
- Нэг сэдвийг олон аргаар зааж болно. Тэр болгонд бэлтгэл өөр өөр байна.

# Хичээлийн судалгаанд үнэлгээ шаардлагагүй

- Хичээлийн судалгаа нь нийт оролцогчид хэлэлцэж илүү сайн заах аргыг боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагаа:
  – Тиймээс оролцогчид нь бүгд арга зүйн талаар өөртөө өгөөж хүртэнэ.
  – Мөн тэр арга зүйг шинэчлэхэд бас хувь нэмрээ оруулна.

# JK –ийн үе шат I A:
# Судлах асуудал,  сэдэв сонгох

- Багш нар хамтарч судалгааны сэдвээ сонгодог. Сургуулийн эрхэм зорилготой холбоотой ерөнхий асуудалд тухайн хичээлээр оруулж болох хувь нэмрийг, тухайн хүүхдэд төлөвшүүлэх боломж байгаа эсэх, хүүхдийн хөгжил төлөвшилтэй холбоотой асуудлыг сонгодог.

A group of teachers works together to come up with a research theme.

This theme is school-wide and focuses on a broad research question regarding their students that involves skills or attitudes they would like to foster.

For example, a research theme may be to determine how to increase independent thinking in students in mathematics.

## Choose a research theme

# JK –ийн үе шат I B:
# Судлах зүйлээ танин барих

- Судалгааны зорилгыг тодруулах шаардлагатай. Сурагчдынхаа чадварыг, төлөвшлийг, хандлагыг, мэдлэг бүтээх процессыг судлах ... зорилгоор ажиглалт явуулна.

  The teachers select a goal and unit of study to focus on and research their students' abilities and needs within this unit of study. For example, they may select a unit on transformational geometry, and the goal of increasing students' abilities to independently apply transformations to concepts of congruence and similarity.

**Focus the research**

# JK –ийн үе шат I C:
# Хичээлдээ бэлтгэх (хичээлээ бүтээх)

- Хүүхдээр мэдлэг бүтээх үйлэнд дуудсан, сэдэл, сонирхол төрүүлсэн, танин мэдэх үйл ажиллагааг судалж ажиглаж болохуйцаар агуулгаа төлөвлөж хичээлийн дидактик алхмуудыг нарийвчлан боловсруулдаг.

- The teachers then select a lesson within the unit to develop, and follow an established lesson plan template (хэв). This template focuses on how the lesson fits within the broader school curriculum, linking the lesson topic and skills to previously learned content, and to content that will be learned in future grades. This lesson plan template also focuses on ways to assess student thinking during the lesson.

## Create the lesson

# JK –ийн үе шат II:
# Хичээлээ явуулах, ажиглалт хийх

- Хичээлийг явуулна, ажиглалт хийнэ. Тодорхой зорилготойгоор олон талаас нь хамтран ажиглана.

The lesson is taught by a member of the group and observed by the other members. The focus of the observation is on student thinking not on the teacher's abilities.

**Teach and observe the lesson**

# JK –ийн үе шат III:
# Хичээлээ хэлэлцэх

- Хичээлээ тодорхой зорилгын доор хэлэлцдэг.

1/2, 2/3 шүүмж ба олзны харьцааг барих

Хэлэлцүүлэгт оролцогчид: хичээл явуулсан багш, хөтлөгч, сургуулийн удирдлага, зөвлөх багш, ажиглагчид

The group then gets together to discuss the lesson and their observations. This is usually done on the same day.

## Discuss the lesson

# JK –ийн үе шат IV A:
# Хичээлээ сайжруулах

- Ажиглалтдаа түшиглэж хичээлийн бэлтгэлээ улам сайжруулаад хичээлийг дахин явуулдаг. Тэгээд ажиглах, хэлэлцэх, сайжруулах үйл ажиллагаагаа давтан хийдэг.

Revisions are made to the lesson, based on their observations and analysis, and another member of the group is selected to teach the lesson again. The process of observation, discussion, and revision repeats.

**Revise the lesson**

# JK –ийн үе шат IV B:
# Олсон зүйлээ баримтжуулах

- Судалж олж мэдсэн зүйлээ баримтжуулах, нийтлэх, түгээх үйл ажиллагаа явуулдаг.

At the end of this process, the group produces a report that outlines what they learned in regards to their research theme and goal.

## Document the findings

# Хичээлийн судалгааны үе шат ба оролцогчдын үүрэг

| | Хичээл явуулах багш | хөтлөгч | Сургуулийн удирдлага | Зөвлөх багш | ажиглагч |
|---|---|---|---|---|---|
| Хичээлийн өмнөх үе: төлөвлөлт | | | | | |
| Хичээлийн үе: хичээл явуулах, ажиглах | | | | | |
| Хичээлийн дараах үе Хэлэлцүүлэг | | | | | |
| Сайжруулах – хичээлийг давтан явуулах | | | | | |

# Европын холбооны улсуудын жишээнээс

- Дидактик, мэргэжлийн дидактик
  - Ухагдахуун: хичээлийн судалгаа, хичээлийн хөгжил, (Unterrichtsforschung, Unterrichtsentwicklung)
- Хичээл, сурах ба багшлах үйл ажиллагааг олон салбар шу-ны зааг дээр авч үздэг
  - “Суралцахуй” – суралцахуйн сэтгэл судлалын онол, арга зүй
  - “Багшлахуй” – дидактикийн онол арга зүй
  - “Хичээлийн хөгжил” – суралцахуй ба багшлахуйн суурь болон туршилтын судалгааны үр дүнг хичээлийн амьдралд хэрэгжүүлэх

# ÁÀÉÃÀËÈÉÍ ÓÕÀÀÍÛ ДИДАКТИК






- Төсөл: Суурь судалгаа, судалгааны үр дүнг хэрэгжүүлэх
- “Математик ба байгалийн ухааны хичээлийн үр өгөөжийг дээшлүүлэх нь”
- “Контекст төвтэй хичээл” – хичээлийн шинэ үзэл баримтлал
- **“Хичээл төвтэй сургуулийн хөгжил”**
  - “Сайн” хичээл гэдгийн дор юуг ойлгож байна вэ?
  - Багшийн өөрийгөө өөрчлөх сонирхол, хэрэгцээ
  - Сургуулийн түвшинд мэргэжил дээшлүүлэх

# Хичээлийн судалгаа манай оронд

- Хичээлийн хөгжил, багшийн арга зүйн хөгжлийн талаар хуримтлуулсан туршлага
  - **Төслүүд** : Данида, Сорос, хичээлийн технологийн шинэчлэл, БДБС, .........ТХБ, ........
  - **Үйл ажиллагаа:** Тэргүүн туршлага, нээлттэй хичээл, багшийн ур чадварын уралдаан, олимпиад,..........:
  - **Сургалтууд:** олон төрөл
  - **Зөвлөмжүүд: стандарт, хөтөлбөр,.....**
    - МБС ба хичээлийн соёлын хөгжил : 5 модуль
    - БУБС ба хичээлийн соёлын хөгжил : 3 модуль
- БСШУЯ, Жайка –ийн төсөл

# Эхний төслийн хүрээнд хуримтлуулсан туршлагын талаар хаанаас мэдэж, яаж ашиглах вэ?

- Төслийн хүрээнд 8 хичээлийн хувьд боловсруулсан 27 гарын авлага
  - Судлах
- Сургалтууд :
  - Жишээ: өнөөдрийн 5 өдрийн сургалт
- Асуудалд шүүмжлэлт сэтгэлгээгээр хандах:
  - Өмнөх төсөлд оролцсон багш нар, сургуулийн одоогийн байдал?
  - Төсөл хэрэгжих гэж буй сургуулийн одоогийн байдал?
- Төсөл амжилттай хэрэгжих гол нөхцөл юу вэ?

# “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” төсөл

- Төслийн онцлог **: “Хичээлийн судалгаа”-** ухагдахуун
- **Японы онцлогтой** сургалтын технологийн тухай яригдаж буйг ухаарах
- Шууд хуулах боломж, хэрэгцээ байхгүй
- Өөрийнхөө нөхцөл байдалд зохицуулан боломжтой, таалагдсан санаануудыг тусгах
- **Судалгаа** : Судлаач багш нар, БХ-ийн эш ажилтнууд, УБ хотын арга зүйчид судалгаанд суурилсан ижил мэдээлэл өгөх
- **Сургууль:** Хичээл дээр төвлөрөх : бэлтгэх, явуулах, сайжруулах
- Маш амархан нэг тодорхойлолтоор илэрхийлэгдэх, нэг далайцаар бүтэх зүйл биш, олон дахин хийсний үндсэн дээр ойлгож, ухаарахыг тооцох

“Эд мэдэхгүй хүн эдийн нэрийг гутаана”

# “ Түгээн дэлгэрүүлэх “ –ийг ойлгомжтой зөв тайлбарлах гарцыг хамтдаа хайх , нэгдмэл ойлголттой болох шаардлага

- Нэг талаас:
  - Багш бүр дахин давтагдахгүй хувь хүн
  - Сурагч бүр...
  - Хөтөлбөр бүр...
  - Хичээл бүр ...
  - Сургууль бүр ..
  - ...
- Нөгөө талаас: Хэн, юу гэдгээс үл хамааран инвариантаар зөөгдөх “нэг юм” байж тараа
  - Бүгдээрээр багшлах үйл ажиллагаа явуулдаг багш мэргэжилтэн
  - Бүгдээрээ сурах үйл ажиллагаа явуулдаг сурагчид
  - ....

# Анхаарал тавьсанд талархлаа